

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл		
1.	“Үйлдвэржилт 21-100” үндэсний хөтөлбөр (2018-2021) ЗГ-ын 36 дугаар тогтоол	Хөтөлбөрийн зорилго: Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт; • Улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг; • Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө; • Концессын гэрээ; • Бусад эх үүсвэр. 		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: СЯ, ГХЯ, ХНХЯ, БСШУСЯ, УУХҮЯ, БОАЖЯ, БХБЯ, ЭХЯ, БХЯ, ХЗДХЯ, ГЕГ, ТЕГ, МХЕГ, СХЗГ, МҮХАҮТ, Аймаг нийслэлийн ЗДТГ, ҮХГ, ХХМТГ, НҮИГ, ОУБ, ШУТСан, Монгол банк, Хөгжлийн банк, ЕСББ, АХБ, СЗХороо, ДБМ лизинг, ЖДҮХС, ХААБ, ТЭДСан, МХС, МЭЕГ, Мэргэжлийн холбоод, ТББ, ШУА, ШУТИС болон бусад их дээд сургуулиуд, МСҮТ, ААН-үүд		
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандартыг нэвтрүүлэн нутагшуулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх; Зорилт 2. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх Зорилт 3. Боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх үйлдвэрүүдийг орон нутагт байгуулах, жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих Зорилт 4. Боловсруулах үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага, эрэлтэд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх; Зорилт 5. Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-ложистикийг боловсронгуй болгож, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэн дотоод, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх.		
		Төсөв (нийт шаардагдах зардал, сая.төг) Нийт-3,045,106.5		
Зардал	Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
	Улсын болон орон нутгийн төсөв	958,376.0	5.65	0.59
	Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө	915,965.5	0,88	0.1
	Концессийн гэрээ	565,100.0	0	0
	Хувийн хэвшил	605,665.0	4,93.0	0.82
	Бусад эх үүсвэр		Хөгжлийн банк 188.2	
		3,045,106.5	199.66	6.5%

1-р зорилтын хүрээнд:
Хүрэх үр дүн :
Үйлдвэрлэлийг санхүү,
хөрөнгө оруулалтын
бодлогоор дэмжих, эрх зүйн
таатай орчинг бүрдүүлэх,
түүхий эд, бүтээгдэхүүний
чанарын стандартыг олон
улсын болон бүс нутгийн
түвшинд хүргэх, нэвтрүүлэн
нутагшуулах;

*1.1 Хонь, тэмээний, ноос, арьс ширэнд урамшуулал олгох тухай
Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах*

ХХААХҮСайдын 2018 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн А-08 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээний дүгнэлт, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажилласан. Журмын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулсан.

Хонины ноосыг биржийн арилжаанд оруулж худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох асуудлыг журмын төсөлд тусган ажлын хэсгийн нарийн бичгийн даргад 2018 оны 04 сарын 23-ны өдөр хүргүүлсэн.

ХШҮ-40 %

1.2 "Түүхий эдийг үйлдвэрт тогтвортой нийлүүлэн нэмүү өртгийн сүлжээ бий болгох боломж" судалгаа хийх

“Малын гаралтай түүхий эд бэлтгэл, тээвэрлэлт нийлүүлэлтийн өнөөгийн байдал, орон нутагт түүхий эдийн тордолтын цэг байгуулах шаардлага, сайжруулах арга замын талаарх судалгаа”-г 2018 оны 08 сарын 30-ны өдрийн А-372 тоот ТНБД-ын тушаалаар ТБОНӨХБАҮХАТ хуульд нийцүүлэн зөвлөх үйлчилгээгээр “Бодлогын шийдэл” ТББ-аар гүйцэтгүүлэн ажлыг хүлээн авсан.

ХШҮ- 100 %

1.5 Худалдааны тухай хуулийн төслийн боловсруулж, УИХ-д өргөн барих

Хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгааг 2500 гаруй худалдаа, үйлчилгээ эрхлэгчдээс авч, үзэл баримтлалын төсөлд тусгав.

Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ, ГХЯ, СЯ, ХЗДХЯ, ГЕГ, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, төрийн бус байгууллага, хувийн хэвшил болон судалгааны байгууллагын төлөөллийг багтаасан 22 хүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулж, “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 14-р зүйлд нийцүүлэн боловсруулж, “Дотоод худалдааны салбарын нөхцөл байдлын судалгаа” зөвлөх үйлчилгээг “Эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт судалгааны хүрээлэн” ТББ-аар гүйцэтгүүлсэн.

2018 оны ХХААХҮ-ийн сайдын А-179 тоот тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А-285, А-295, А-314 дугаар тушаалын дагуу зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр “Хөдөө аж ахуйн хөгжил эрх зүйн шинэтгэл ТББ” шалгаруулан гэрээ байгуулж, Худалдааны тухай хуулийн 1-р шатны урьдчилан тандан судалгааг хийлгүүлсэн. Тандан судалгаанд үндэслэн ажлын хэсэг хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.

ХШҮ- 70%

1.6.Түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, үйлдвэрүүд дотооддоо хоршин ажиллах үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтын талаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах

Сангийн яамнаас боловсруулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд "Арьс ширэн түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах, экспортлох чиглэлээр үйлдвэрүүдийн хоршин ажиллах үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалт"-ын талаар санал тусгуулсан.

“Монгол улсын тогтвортой байдлын үзэл баримтлал 2030”-ын 2.1.3 дахь заалт болон дотоодын үйлдвэрүүдээс ирүүлсэн санал хүсэлтэд үндэслэн ХХААХҮЯ-ны Сайдын 2018 оны 06-р сарын 13-ны өдрийн 01/2240 тоот албан бичгээр “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-д

угаасан ноолуурын биржийн хураамжийг нэмэгдүүлж, самнасан ноолуурын биржийн хураамжийг бууруулах саналыг хүргүүлсэн.

Биржийн шимтгэл боловсруулалтын төвшнөөс хамаарахгүйгээр 0.32% байсныг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 05-р сарын 31-ны өдрийн 04 тоот тогтоолоор угаасан ноолуурт 1% болгон нэмэгдүүлж, самнасан ноолуурт 0.2% болгон бууруулж бодлогын зохицуулалтыг хийсэн. Угаасан ноолуурын экспорт өмнөх онтой харьцуулахад 2.3%-иар буурч, самнасан ноолуурын экспорт 8.45 %, бэлэн бүтээгдэхүүн 8.5%-иар тус тус өссөн байна.

ХШҮ- 70 %

1.8 Дотоодод үйлдвэрлэх боломжгүй түүхий эд, бүтээгдэхүүн, туслах материалын импортын гаалийн болон НӨАТ-ыг бууруулах чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулж батлуулах

Дотоодод үйлдвэрлэх боломжгүй 21 чиглэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн татвараас чөлөөлүүлэх асуудлыг Засгийн газрын 168 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Уг тогтоол 2018 оны 12 сарын 31 хүртэл хэрэгжих тул дахин хугацааг сунгах чиглэлээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.

ХШҮ- 100 %

1.9 Боловсруулах үйлдвэрүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих, тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бий болгох шийдвэрийн төсөл боловсруулах б/ Санамж бичиг, гэрээ байгуулах

Монгол банк, МУХБ-тай хамтран ажиллаж, 500 хүртэлх тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлсэн. Хөгжлийн банкны эх үүсвэрээс үйлдвэрлэгчдэд зээл олгохоор Ноолуур хөтөлбөрийн зээлийн нөхцөл тохирох гэрээ байгуулсан.

Хөгжлийн Банк нь 6 үйлдвэрт шууд зээлийн 96.6 тэрбум төгрөг, Голомт, Хаан, ХХБ, Хас, Капитрон банкуудаар дамжуулан 14 үйлдвэрт 91.6 тэрбум төгрөг, нийтдээ 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгосон. Дэлхийн банк, Монгол банк, Хөгжлийн банк, Монгол дахь олон улсын байгууллагууд, Монгол, ОХУ, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн чуулга уулзалтын үеэр хөрөнгө оруулалт татах зорилгоор үйлдвэрлэлийн томоохон төслүүдэд танилцуулж ирлээ. Үүнд: Дэлхийн банк, Хөгжлийн банкинд 700 мян.ам доллар, 2019 оны Үндсэн чиглэлд 753 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгуулахаар саналаа хүргүүлэв.

ЖДҮХСан нь 2018 оны 4-р сард 1031 төсөл, 2018 оны 8-р сард 511 төсөл, нийт 1542 төсөл хүлээн авч хянан журмын шаардлага хангасан 216 төслийг шалгаруулж, санхүүжилт олгох ажлыг зохион байгуулан ажилласан. 2018 оны 12-р сарын 31-ны байдлаар 212 иргэн, аж ахуй нэгжид 3 %-ийн хүүтэй 5 жилийн хугацаатай 96.37 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Зээлийг барилгын материалын чиглэлээр 27 үйлдвэрт 15,12 тэрбум, Мал аж ахуйн чиглэлээр 30 үйлдвэрт 13,5 тэрбум, газар тариалангийн чиглэлээр 28 үйлдвэрт 14,29, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 37 үйлдвэрт 10,33, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 55 үйлдвэрт 25,47, худалдаа, үйлчилгээний чиглэлээр 15 үйлдвэрт 7,9 тэрбум, зоорийн 10 үйлдвэрт 4,13 тэрбум, бусад 10үйлдвэр 5,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

ХШҮ-100%

1.12 "Монгол экспорт" хөтөлбөрийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах

Монгол экспорт хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 9-р сарын 05-ны

өдрийн 278 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах ажлыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцаж байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Гадаад харилцааны сайдын 2018 оны А/114 дүгээр тушаалаар батлуулан холбогдох яам, газруудад хүргүүлэв. Мөн Засгийн газрын 2018 оны 37 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу Монгол экспорт хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн талаарх уулзалтыг СЯ, ХХААХҮЯ, МУХБ, ГЕГ, Монголын экспортлогчдийн холбооны төлөөллийг оролцуулан зохион байгуулав. Уулзалтад оролцсон төлөөллүүд Экспортыг дэмжих үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдаар ахлуулан байгуулах, уг зөвлөлийн дэргэд бие даасан ажлын алба ажиллуулах нь илүү үр дүнтэй гэсэн санал зөвлөмж гарсны дагуу зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын төсөл боловсруулж, Засгийн газрын шийдвэрийн төслийн хамт ЗГХЭГ-г танилцуулан чиглэл авав. Үүний дагуу уг зөвлөлийг Гадаад харилцааны сайдаар ахлуулан байгуулахаар Ерөнхий сайдын захирамжын төсөл боловсруулан холбогдох газруудаас санал авч ЗГХЭГ-г хүргүүлэв.

“Монгол экспорт экспо” нэгдсэн арга хэмжээг Монголын ноос, ноолуурын холбоо, Арьс, ширний үйлдвэрлэлийн холбоо, Мишээл экспо ХХК-тай хамтран ажиллаж зохион байгуулж, тус арга хэмжээнд зориулж Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 10-р сарын 16-ны өдрийн А460 тоот тушаалаар 28 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Худалдааг хөнгөвчлөх экспортыг нэмэгдүүлэх үүний дотор уул уурхайн бус, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээний дүнд 2018 оны статистик мэдээгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 12,8 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд экспортын хэмжээ 7,0, импортын хэмжээ 5,8 тэрбум ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 1,0 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

ХШҮ-100%

1.15. Татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтуудыг хэрэгжүүлэх, бизнесийн өрсөлдөхүйц, таатай орчин бүрдүүлэх, жижиг дунд бизнесийг дэмжих, олон улсын татварын шинэлэг зарчмуудыг өөрийн орны нөхцөлд нийцүүлэн нэвтрүүлэх, сүүлийн үед гарч байгаа татвараас зайлсхийх явдлаас дотоодын татварын бааз суурийг хамгаалах, татварын бааз суурийг цаашид өргөжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгааг харгалзан татварын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан улс орон даяар хэлэлцүүлгийг зохион байгуулж, хуулийн төслөө 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн бариад байна.

Татварын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлснээр нэг талаас жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах замаар, нөгөө талаас татвараас зайлсхийх, зугтах явдлын эсрэг олон улсын туршлагаадаас нэвтрүүлэх замаар татварын бааз суурийг өргөжүүлнэ.

ХШҮ-100%

1.16. Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх, хүрээлэнгүүдийн чадавхийг бэхжүүлэх,

Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн, Ой модны сургалт судалгааны хүрээлэн, хөнгөн үйлдвэрийн судалгаа,

туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци /Армоно/ ТӨААТҮГ зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудыг яамны харьяанд авах талаар БТГ-тай хамтран санал боловсруулж ЗГХЭГ-г хүргүүлсэн. Тус байгууллагуудаас ирсэн хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж, хүрээлэнгүүдийн чадавхийг бэхжүүлэхэд Монголд хэрэгжиж буй гадаад орны донор төслүүдийг чиглүүлэн ажиллаж байна.

Ноос, ноолуурын ширхэгтийн SEM (Scanning electron microscopy) төхөөрөмжийг нийлүүлэхээр 508.2 сая төгрөгийн тендэр зарлан, тендэрт шалгарсан Пи Пи Пи ЭМ Жи Эл ХХК-тай тус төхөөрөмжийг нийлүүлэхээр 181210/07-533 тоот гэрээ байгуулан нийлүүлсэн.

Орчны чийглэг, агааржуулалтыг тохируулах төхөөрөмжийг нийлүүлэхээр 121,4 сая төгрөгийн нээлттэй тендэр зарлан “NEW BEST CHOICE” компанийг сонгон шалгаруулан гэрээ хийсэн.

Арьс ширний гистологийн шинжилгээнд хэрэглэгдэх парафин цутгагч аппарат, слайд будагч аппарат 90.0 сая төгрөгөөр нийлүүлэв.

ШУТИС-ХСТ-д "Үйлдвэрлэл сургалтын загвар төв" байгуулахад тоног төхөөрөмж, программ хангамжийн дэмжлэг үзүүлэх 168,1 сая төгрөгийн нээлттэй тендер зарлан шалгарсан Пи Пи Пи ЭМ Жи Эл ХХК-тай тус төхөөрөмжийг нийлүүлэхээр гэрээ байгуулан нийлүүлсэн.

ХШҮ-100%

1.17. ЗГ-ын 2015 оны 336-р тогтоолоор баталсан дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах

ЗГ-н 2015 оны 336-р тогтоолоор баталсан дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг шинэчлэн батлах тогтоолын төслийг боловсруулан, холбогдох яам, агентлагаас санал авч байна. Мөн 2017 оны дотоодын худалдан авалтын тайлан мэдээг зохих газруудаас авч анализ-мониторинг хийв. 2017 онд төсвийн хөрөнгөөр 45 төсвийн ерөнхийлөн захирагч 64.0 тэрбум төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит 25 байгууллага 111.0 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрээс худалдан авсан байна.

2016 онд нийт 71 төрийн байгууллагын дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний дүн хэмжээ 147,5 тэрбум төгрөг байсан бол 2017 онд 175 тэрбум болж 20%-иар нэмэгдсэн байна.

2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 56 төсвийн ерөнхийлөн захирагчид болон 45 төрийн өмчийн оролцоотой компанийн худалдан авалт 210 тэрбум төгрөгт хүрч, урьдчилсан гүйцэтгэлээр худалдан авалт 12 хувиар нэмэгдсэн байна. /Жилийн эцсийн тайлан мэдээ дараа оны 6 сард гардаг/

Жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал ирүүлэх талаар 20 орчим мэргэжлийн холбоодод хандаж 14 бүлгийн 175 нэр төрлөөр ирүүлсэнг нэгтгэв.

ХШҮ-100%

1.20. Стратегийн хүнсэн дэх тарифын бус хязгаарлалтыг олон улсын жишигт хүргэх, холбогдох журамд өөрчлөлт оруулах;

Засгийн газрын 2013 оны 77 дугаар тогтоолоор баталсан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж, журмыг боловсруулж байна.

ХШҮ-40%

	<p><i>1.21 Үйлдвэрийн техник, технологийн чиглэлээрх үндэсний стандартыг боловсронгуй болгох, олон улсын дэвшилтэт стандартуудыг нутагшуулан нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх</i></p> <p>Ерөнхий сайдын 2018 оны 97 дугаар захирамжийн дагуу ХХААХҮЯ-ны ТНБД-ын А-361 тушаалаар хөнгөн, нийтийн хоол, ахуй үйлчилгээний чиглэлээр 8 дэд ажлын хэсэг байгуулагдан үндэсний 750 MNS, 600 орчим ISO стандартад шинжлэх ухаан, техникийн түвшинд үзлэг хийж, шинэчлэх болон шинээр боловсруулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх стандартын жагсаалтыг гаргав.</p> <p>2018 онд хөнгөн үйлдвэрийн салбарын 16 стандартыг шинэчлэх, боловсруулах, орчуулан нутагшуулах ажлыг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А-463, 2018 оны 10 сарын 25-ны өдрийн А-482, 2018 оны 11 сарын 14-ны өдрийн А-515 дугаар бүхий ТНБД-ын тушаалаар салбарын шинжлэх ухаан болон төрийн бус байгууллагуудаар ТБОНӨХБАҮХАТ хуульд нийцүүлэн зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлэв. Ажлын даалгаврыг боловсруулан шаардлага хангасан 14 стандартыг хүлээн авсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
Зорилт 1-ийн дундаж үнэлгээ-85.0%	
<p>2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн : Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх;</p>	<p><i>2.1 Түүхий эд бэлтгэх, хадгалах, чанарыг хамгаалах, тээвэрлэх үе шатанд мөрдөх стандарт, арга зүй, үнэ цэнийн сүлжээг бий болгох чиглэлээр сургалт явуулах;</i></p> <p>Арьс ширэн түүхий эд бэлтгэх сургалтын контент хийх зөвлөх үйлчилгээг "Толгой медиа" ХХК-аар 9 сая төгрөгөөр, ноос, ноолууран түүхий эд бэлтгэх сургалтын контент хийх зөвлөх үйлчилгээг "Пропекс" ХХК-аар 2018 оны 07 сарын 10-ны өдрийн ТНБД-ын А-313 дугаар тушаалаар ТБОНӨХБАҮХАТ хуульд нийцүүлэн тус тус гүйцэтгүүлэн хүлээн авсан.</p> <p>Зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлсэн контентуудыг аймаг орон нутагт сургалтад хэрэглэж эхэллээ. Архангай, Ховд, Завхан, Дундговь аймгуудад сургалт явуулсан.</p> <p>Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны арга хэмжээг олон нийтэд сурталчилах нэвтрүүлгийг "Хурц үзэг" ХХЗ-ийн Малчин телевизээр, ТВ-9 телевизийн 1-р сувгаар цацах хамтран ажиллах гэрээ байгуулж сурталчилсан.</p> <p>2018 оны 5 дугаар сард Баянхонгор аймгийн Баянцагаан сум, Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумдад “боловсруулаагүй ноолуурын төвлөрсөн дуудлага худалдааг” нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулж, биржийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж, малчид, хоршоо биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих UNIDO төслийн хүрээнд МАШҮХ-той “Арьс, ширний чанарыг сайжруулах” сургалт зохион байгуулах, арьс ширний эдийн засгийн, чанарын үнэлгээ хийх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Нядалгааны 5 цех (Дархан Мийт Фүүдс, Эрд мийт, Мах Маркет, Мах Импекс, Мийт Фүүдс) дээр үнэлгээ хийж байна. Арьс шир боловсруулах 3 үйлдвэр (Дархан Нэхий, Дархан Минж, Мон Ирээдүй) дээр 1000 арьс, ширний гэмтлийн судалгаа хийж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p><i>2.2. Орон нутагт түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулах лабораторийн чадавхийг сайжруулах</i></p> <p>2018 онд ЗГ-ын 12 дугаар тогтоолоор “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг баталсан. Тухайн хуулийг дагаж гарах “Мал эмнэлгийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх заавар”, “Лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ, түүнийг хэрэглэх заавар”, “Мал</p>

эмнэлгийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”, “Мал бэлтгэх, тээвэрлэх, тууварлах, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг, хорио цээрийн журам” зэрэг шинэчлэн боловсруулсан журам, зааврыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулахаар ажиллаж байна.

Лабораторийн сүлжээ цахим программ /www.vet.shinjilgee.mn/ 2016 оноос эхлэн бүх аймгуудад нэвтрүүлж, нийслэл болон бусад аймгуудын лабораториос малын өвчний оношлогоо, шинжилгээ түүхий эдийн гарал үүслийн шинжилгээг баталгаажуулан нэгдсэн мэдээлэлд оруулах нөхцөл бүрдүүлэв. ШХА-аас хэрэгжүүлсэн “Ногоон алт-малын эрүүл мэнд” төсөлд хамрагдсан Архангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Хөвсгөл, Төв зэрэг 6 аймгийн 15 сумын мал эмнэлгийн тасаг, нэгжийг дээрх цахим мэдээллийн системд холбох, мах, махан, сүү сүүн бүтээгдэхүүнд малын эмийн үлдэгдлийн шинжилгээ зөөврийн багаж, урвалж бодис нийлүүлж, эмч нарт ажлын байрны сургалт явуулав. Түүнчлэн мал, малын түүхий эдийн гарал үүслийг тодорхой болгох нэгдсэн бүртгэлд оруулах цахим технологи нэвтрүүлэх туршилт судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэв.

Мөн ДАЭМБ-ын ихэрлүүлэх төслийн хүрээнд Англи, Япон улсын судлаачидтай хамтран Сэлэнгэ, Дорнод аймгийн Мал эмнэлгийн лабораторийг түшиглэн төвийн бүсийн малын эмч, мал эмнэлгийн хяналтын байцаагч нарыг хамруулан гоц халдварт өвчин болон эмгэг судлалын шинжилгээний шинэ арга зүй эзэмшүүлэх сургалт зохион байгуулав. Орон нутгаас импорт, экспортын (ОХУ, Казакстан, Лаос) болон үржлийн мал амьтанд ям, даурин, хламидиоз, сүрьеэ, сохор догол, листериоз, иж балнад, даурин, хэл хөхрөх, бруцеллезын баталгаажуулах шинжилгээ хийж гүйцэтгэж, аймгийн лабораториудын оношлогооны ур чадварт үнэлгээ өгөх, залруулга, сургалт хийх ажлыг гүйцэтгэв.

ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хүрээнд нээлттэй тендер 2, харьцуулсан тендер 11-ийг тус тус зохион байгуулж сонгон шалгаруулалт явуулж төсөл, хөтөлбөрийн хүрээнд аймаг, нийслэл, УМЭАЦТЛ-ийн нэгж тасаг, лабораториудад шаардагдах оношлуур, урвалж бодис, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж нийлүүлэгдэж оношлогоо, шинжилгээ, тандалт судалгаа, засвар үйлчилгээний ажлыг амжилттай явуулав.

УМЭАЦТЛ болон 21 аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторид шаардагдах оношлуур, урвалж бодис, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн захиалгыг хийж ХХААХҮЯ, ЗГХА МЭҮГ-т хүргүүлснээр тендер зарлагдаж нийлүүлэгч сонгон шалгарч, бараа материал нийлүүлэгдсэн.

Тус лабораторийн өргөтгөлийн дуусаагүй барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгүүлэх тендерийг зохион байгуулж барилгын өргөтгөлийн ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалт хийгдэж 693 сая төгрөгийн өртөг бүхий барилгын өргөтгөлийн ажлыг “Жаргалант луу” ХХК амжилттай гүйцэтгэж байна.

ХШҮ-100%

2.3 Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг тодорхойлох, бүртгэх, хянах тогтолцоог бий болгох, /мэдээллийн нэгдсэн сан, цахим сүлжээ/,

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнд олгох мал эмнэлгийн гэрчилгээний системийн үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газар, ШХА-ийн “Ногоон алт - малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран “Мал эмнэлгийн гэрчилгээний систем”-ийг хөгжүүлж мал, амьтны эрүүл мэнд, бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй, гарал үүслийг тодорхой болгох

туршилтын төслийг 2017 оноос туршиж эхэлсэн бөгөөд 2018 онд Төв, Архангай, Баянхонгор, Завхан, Ховд, Хөвсгөл аймгийн болон эдгээр аймгуудын төсөлд хамрагдсан сумдын Засаг даргын тамгын газар, ХХААГ, сумын мал эмнэлэг, үржлийн тасаг, тухайн сумдын нийт 6,800 орчим малчдыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Мөн сургалтын үеэр Мал эмнэлгийн тасгийн бүртгэл мэдээллийн программ хангамж шинээр суулгаж RFID-тай ээмэгний мэдээлэл уншигч, компьютер тоног төхөөрөмж олгож газар дээр нь туршиж мэдээлэл дамжуулах ажлыг зохион байгуулав. МЭЕГ энэхүү гэрчилгээжүүлэлтийн системийг 2019 оноос эхлэн орон даяар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээний загвар, холбогдох шийдвэрийн төсөл, эрх зүйн баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А-170 дугаар тушаалаар байгуулсан.

Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэх, малын гаралтай нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээг хэрэгжүүлэх зорилготой ажлын хэсгийн даргаар ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, дэд даргаар тус яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга нар ажиллаж, уг арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахад "Мах импекс", "Мах маркет", "Эрд мийт", "Дархан меат фүүдс", "Булган мах маркет", "Баяндэлгэр хүнс" гэсэн махны үйлдвэр, "Хатант Интернэшнл" ХХК, "Дархан нэхий" ХК, "ДЦС-4" ТӨХК, "Номадс" сүлжээ ресторан, 58 дугаар сургууль гэсэн аж ахуйн нэгж, байгууллага, "И-март", "Номин", "Лавай", "Гүүд прайс" зэрэг аж ахуйн нэгж, байгууллага идэвх, санаачилгатай оролцов. Тус ажлын хүрээнд зах зээлд нийлүүлэгдэх малыг ээмэгжүүлэн гарал үүслийг тогтоон Мал бүртгэлжүүлэлтийн ач холбогдлыг нийтэд сурталчлан улмаар малын бүртгэлээр дамжуулан гарал үүслийг тодорхойлон баталгаажсан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн гар дээр хүрэх нөхцлийг бүрдүүлэв.

ХШҮ-100%

2.4. Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагаатай уялдуулан сумдад байгуулах

Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, орон нутагт итгэмжлэгдсэн агуулахын үйл ажиллагааг эхлүүлэх, нэгдсэн мэдээллийн систем дээр тулгуурлан малчид, хоршоодын түүхий эдийг биржээр дамжуулан эцсийн худалдан авагч /үйлдвэр/-дэд шууд худалдах зорилгоор 57 хоршоонд биржийн итгэмжлэл олгож, зарим нь арилжаанд орж байна. Говь-Алтай, Архангай, Дорноговь, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгийн төвд хувийн хэвшилд тулгуурласан ложистикийн төвийг байгууллаа.

ХШҮ-100%

2.5. Арьс ширийг хөдөө аж ахуйн биржээр арилжих талаар судалгаа тооцоолол хийх

Засгийн Газраас баталсан “Үйлдвэржилт 21:100”, “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрүүдийг үндэслэн “Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгөх тогтолцоо” арга хэмжээг ХХААХҮЯ-ам, Нийслэлийн ЗДТГ газар, Мал эмнэлгийн ерөнхий газар, МХЕГ газар, аймгуудын ЗДТГ, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, олон улсын байгууллагуудтай /ADB, UNIDO, ШХА/ хамтран хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээний хүрээнд Хөдөө аж ахуйн бирж, малчид, хоршоодын мах,

арьс, ширийг дотоодын үйлдвэрүүдэд форвард гэрээний арилжаагаар нийлүүлэх, дотоодын үйлдвэрийн махыг худалдааны байгууллагуудад, арьс, ширийг боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулна. Бирж нь малын гоц халдварт өвчингүй, эрүүл бүсээс мал эмнэлгийн үйлчилгээнд бүрэн хамрагдсан, эмийн үлдэгдэлгүй малын махыг хүнсний хэрэгцээнд нийлүүлэх, малын амьдын болон нядалгааны үеийн гэмтэлгүй арьс ширийг боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх, форвард гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллахаар тусгагдсан. Бирж нь эдгээр арга хэмжээний ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

2018 оны 11 дүгээр сарын 1-нд Форвард гэрээний нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, оролцогч байгууллагууд санамж бичиг болон форвард гэрээнд гарын үсэг зурсан. Форвард 6 гэрээ хийгдсэнээс махны гэрээ-4, арьс ширний гэрээ-1, амьд малын гэрээ-1 байна. Санамж бичиг 7 хийгдсэнээс махны-2, арьс, ширний-3, амьд малын санамж бичиг-2 хийгдсэн байна. Цаашид гэрээнд заагдсаны дагуу ажил үргэлжлэн явагдаж байгаа бөгөөд худалдах, худалдан авах гэрээнд хяналт тавин ажиллаж байна.

Арга хэмжээнд оролцогч байгууллагуудыг бүртгэлжүүлэх, худалдах болон худалдан авах нэгдсэн захиалгын санг Биржийн www.mse.mn веб сайтад шинээр order-mse цэс нээж, уг цэсэнд мэдээлэл оруулах, захиалгыг шинэчлэх, гэрээний гүйцэтгэлийг хангуулах ажлуудыг хийж байна.

Биржийн итгэмжлэгдсэн 58 хоршоо, “Ногоон алт” төсөлд хамрагдсан 89 хоршоо, нийт 147 хоршоодтой холбогдож мал, мах болон арьс шир нийлүүлэх тандалт судалгааг хийж гүйцэтгэсэн.

ХШҮ-100%

2.7 Малчдын хоршоо, боловсруулах үйлдвэрийн түүхий эд бэлтгэлийн агуулах, тоног төхөөрөмж сайжруулахад дэмжлэг үзүүлэх

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл”-ийн хүрээнд төслийн нэгжийг 2018 оны 11 сард байгуулсан. Төслийн хүрээнд цаашид Жижиг хүнсний ногооны фермерүүдэд групп, нийгэмлэг үүсгэн хэрхэн үр ашигтай хамтран ажиллах боломжтой талаар сургалт зохион байгуулж, Борнуур, Орхон, Ерөө, Улаангом суманд ойролцоогоор 30 фермерүүдийн нийгэмлэг/групп байгуулах бөгөөд нэг группт 5-6 фермер гэр бүлийг оролцуулахаар төлөвлөж байна.

Түүхий эдийг чанар, хадгалалт, хүлээн авалтыг сайжруулах зорилгоор ШХА-ын “Ногоон алт-малын эрүүл мэнд” төслийн 240 сая төгрөгийн санхүүжилтээр Өвөрхангай аймагт-3, Хөвсгөлд-3, Хэнтийд-1, Баян-Өлгийд-3, нийт 10 түүхий эдийн агуулахыг ашиглалтанд оруулсан байна.

Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар Архангай аймгийн Өндөр улаан суманд арьс ширэн түүхий эдийн анхан шатны тордолтын цехийг "Малчин түмний буян" хоршоог түшиглэн жишиг хоршоо байгуулахаар тоног төхөөрөмжийг суурилуулан, эхний хөрөнгө оруулалтаа хийсэн.

ХШҮ-100%

2.8 Алслагдсан бүс нутагт элеватор барих /Сэлэнгэ аймагт 13.0 мян. тн үр тариа хадгалах, 2.0 мян. тн үрийн буудай хадгалах цогцолбор барих/

2018 онд ТЭДС-аас Сэлэнгэ аймгийн Шаамар суманд Дулаанхан тосгонд 2000 тн, Хөтөл салбарт 2000 тн багтаамжтай үрийн агуулах байгуулсан. ОХУ-ын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр 13.0 мян тн багтаамжтай элеватор байгуулахаар саналаа хүргүүлсэн. Эцэслэн шийдвэрлээгүй байна.

		<p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p><i>2.9. Төв, суурин газрыг түшиглэн зоорь, агуулах байгуулах</i> 2018 онд Улсын төсвийн хөрөнгөөр Ховд аймгийн Жаргалант суманд хүнсний ногооны 1000 тонн багтаамжтай хүнсний ногооны зоорь, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум, Сэлэнгэ аймгийн Жавхлант суманд 100 тонн багтаамжтай хүнсний ногооны зоорь байгуулсан. УБ хотод төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, махны хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах ТЭЗҮ боловсруулсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
Зорилт 2-ын дундаж үнэлгээ 92.5%		
<p>3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх үйлдвэрүүдийг орон нутагт байгуулах, жижиг дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:</p>		<p><i>3.3 Ховдын цэвэрлэх байгууламжийг байгуулах</i> Арьс, шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн хоногт 8000м3 ус үйлдвэрлэх, арьс шир боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн үйлдвэр 11,8 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс энэ онд төсөвт 710.0 сая төгрөг тусгагдаж, тендер зарлан түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр “Саруул цамхаг” ХХК шалгарч зураг төслийг боловсруулан цахилгааны дэд өртөө хашаа гражны ажил хийсэн. Хяналтын гэрээг Ховд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай байгуулав. Гүйцэтгэгч компани 710 сая төгрөгний ажлыг хийж гүйцэтгэсэн нь нийт барих байгууламжийн 26 хувийг эзэлж байна. Үйлдвэрийн цахилгааны техникийн нөхцөлийг "Ховдын цахилгаан түгээх сүлжээ" компаниас 2018 онд олгосоноор цахилгаан хангамжийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p><i>3.6 Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт технологитой, өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн ТЭЗҮ, зураг төсвийг хийх</i> Хүнсний эслэг ихээр агуулсан жимсний хальс, навч, хүнсний ногоо, ургамал, жимс жимсгэнэ зэрэг эх орны түүхий эдийн шинэ нөөц ашиглан хийх "Эрүүл мэндэд чиглэсэн импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. Уг тайланд эрүүл мэндэд чиглэсэн найрлага бүхий эх орны түүхий эдийн шинэ нөөц ашиглалт, технологийн тооцоо, үйлдвэрийн зардал, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын тооцоо, тоног төхөөрөмжийн байршлын болон ерөнхий төлөвлөлтийн зураг зэргийг тусгасан бөгөөд энэхүү жишиг техник эдийн засгийн үндэслэлийн дагуу ундаа, шүүсний үйлдвэр байгуулах боломж бүрдсэн. Ингэний сүү боловсруулах үйлдвэрийн байршил, газар, дэд бүтцийг шийдвэрлүүлж, үйлдвэрийн зураг төсвийн ТЭЗҮ-ийг "Монгол тэмээ корпораци" ХХК-иар орон нутгийн төсвөөр гүйцэтгүүлсэн. "Хүүхдийн сүүний үйлдвэр байгуулах" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. "Цэвэр өсгөврийн хөрөнгө үйлдвэрлэх" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. ТЭЗҮ боловсруулснаар үйлдвэр байгуулах зардал, технологийн тооцоо, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын тооцоо, тоног төхөөрөмжийн тооцоо, байршлын болон ерөнхий төлөвлөлтийн зураг зэргийг тусгаснаар үйлдвэр байгуулах боломж бүрдсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>

3.7 Орон нутаг, нийслэлд 100-аас доошгүй үйлдвэрийг шинээр барьж байгуулах, шинэчлэхэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх

2018 оны улсын төсөвт 97.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр батлагдсантай холбогдуулан ЖДҮХСан нь 2018 оны 4-р сард 1031 төсөл, 2018 оны 8-р сард 511 төсөл, нийт 1542 төсөл хүлээн авч хянан журмын шаардлага хангасан 216 төслийг шалгаруулж, санхүүжилт олгох ажлыг зохион байгуулан ажилласан. 2018 оны 12-р сарын 31-ны байдлаар 212 иргэн, аж ахуй нэгжид 3 %-ийн хүүтэй 5 жилийн хугацаатай 96.37 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.

Зээлийг барилгын материалын чиглэлээр 27 үйлдвэрт 15.12 тэрбум, Мал аж ахуйн чиглэлээр 30 үйлдвэрт 13.5 тэрбум, газар тариалангийн чиглэлээр 28 үйлдвэрт 14.3, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 37 үйлдвэрт 10.3, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 55 үйлдвэрт 25.47, худалдаа, үйлчилгээний чиглэлээр 15 үйлдвэрт 7.9 тэрбум, зоорийн 10 үйлдвэрт 4.13 тэрбум, бусад 10 үйлдвэр 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрүүдээс байршил, үйл ажиллагааны чиглэл таарч буй 16 үйлдвэрт 5.1 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсан байна.

Бүтээн байгуулалтын ажил 100 хувь хийгдэж үйлдвэрлэл эхэлсэн 7 аймгийн 9 үйлдвэр, 70-90 хувийн гүйцэтгэлтэй 13 аймгийн 14 үйлдвэр, бүтээн байгуулалтын тодорхой ажил хийгдэж эхэлсэн 50 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй 6 аймгийн 7 үйлдвэр буюу нийт 30 үйлдвэр байна. Үүнээс 3 үйлдвэр өргөтгөл хийгдэж, 27 үйлдвэр нь шинээр байгуулагдсан байна. НЭМЭЛТ ТАЙЛАНГ ХАВСРАЛТАД ТУСГАВ.

ХШҮ-70%

3.8. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа, технологийн шинэчлэл хийсэн үндэсний үйлдвэрийн судалгааг хийх

ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А-575 тоот тушаалаар ноос ноолуурын салбарт Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж буй үйлдвэр, аж ахуй нэгжийн судалгаа, технологийн түвшний нарийвчилсан үнэлгээ хийлгэх судалгааг зөвлөх үйлчилгээгээр ТБОНӨХБАҮХАТ хуульд нийцүүлэн "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэн ажлыг хүлээн авсан. Ноос, ноолуурын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа 203 аж ахуйн нэгж байна. Үүнээс 36 нь экспортод бүтээгдэхүүнээ гаргаж байгаа бөгөөд 28 нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30%-аас дээш хувийг экспортод гаргаж байна.

ХШҮ-100%

3.18 Франчайзинг нэвтрүүлэх олон улсын зөвлөгөөнд оролцох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх инновацийг тодорхойлох, хэрэгжүүлж эхлэх

Франчайзинг нэвтрүүлэхээр Дархан -Уул аймгийн арьс ширний гүн боловсруулах хөгжлийн загвар үйлдвэр, ноос ноолуурын зэрэг үйлдвэрүүдийг тодорхойлоод байна. Тус аймагт арьс ширний гүн боловсруулах хөгжлийн загвар франчайзинг үйлдвэр байгуулах чиглэлээр Европын Холбооны Улсын Бельги, Итали, Герман зэрэг улсын туршлага судлан үзэсгэлэнд оролцож энэ талаар Италийн арьс ширний АССОМАК холбоотой хамтран ажиллахаар тохиролцов.

Монпеллетс” ХХК нь франчайзинг нэвтрүүлж монгол хурганы болон ахрын ноосоор **био бордоо** үйлдвэрлэн Берлин хотын Хумболдын Их сургуультай 2005-2007 онд хамтран технологи инновацийн бүтээгдэхүүн гаргасан. Төв аймгийн Эрдэнэ суманд

		<p>орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж суурилагдсан үйлдвэрээ 2018 оны 9-р сард байгуулан, Герман Япон, Солонгос болон дотоодын зах зээлд нийлүүлж байна. Уг бордоо нь экологийн цэвэр бүтээгдэхүүнээс гадна ургацыг 2-3 дахин нэмэгдүүлдэг, баруун Европ, Азийн зарим оронд экспортод гардаг, зах зээлийн өндөр үр ашигтай инновацийн бүтээгдэхүүн болоод байна.</p> <p>Дараахь шинэ технологи нэвтрүүлж инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд: Уламжлалт үндэсний монгол дээлийг орчин үеийн нано технологиор гарган авсан гал болон ус нэвтэрдэггүй материалаар “Хадлан” дээлийг “Three flames” ХХК ны загвар зохион бүтээгчид бүтээн, инновацийн эрэлт өндөр бүтээгдэхүүн болоод байна. Дотоод зах зээлээс гадна АНУ, Герман, Францад эрэлттэй, борлуулалт өндөр бүтээгдэхүүн болсон.</p> <p>Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэнд “Гарааны био ундарга” ХХК-ий “Ризо” шингэн бордооны үйлдвэр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. <i>Шингэн бордооны хувьд ашиглаж, түгээхэд хялбар, үр дүн сайтай. Уг бордоог ашигласнаар үрт ургамлуудыг 10-20 хувь, төмсийг 15-25 хувь, улаан лооль, өргөст хэмх зэрэг нарийн ногоог 20-40 хувь хүртэл ургацыг нэмэгдүүлэх боломжтой. Энэхүү үйлдвэр нь жилдээ 300 тонн шингэн био бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай юм.</i></p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p><i>3.21 Хөтөлбөрт тусгасан шинээр байгуулах, шинэчлэх үйлдвэрүүдийг эрчим хүчээр хангах судалгаа тооцоог хийх</i></p> <p>Эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төвийн хүсэлтийн дагуу Хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон компаниудын нэр, байршил, улирлын чанартай ажиллах хугацаа, цахилгааны ачааллын мэдээллийг салбаруудаар гарган хүргүүлэв. Хэнтий аймгийн Баянхутаг, хөвсгөл аймгийн Галт сумдад барьж буй хуурай сүүний үйлдвэрүүдийн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэснээр үйлдвэр үйл ажиллагаагаа эхлэх боломж бүрдсэн.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40</p>
		<p style="text-align: right;">Зорилт 3-ийн дундаж үнэлгээ 70.0%</p> <p><i>4.1 Хөнгөн, хүнсний салбарт хамаарах ажил мэргэжлийн нэршил, тэдгээрийн индекс кодыг шинэчлэх;</i></p> <p>БСШУС-ын Сайдын 2016 оны А/150 дугаар тушаалыг шинэчлэн батлуулах бэлтгэл хангагдаж байна. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд болон мэргэжлийн холбоод, ажил олгогчид, Азийн хөгжлийн банкны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-өөс ирүүлсэн мэргэжлийн нэр, индексийг шинэчлэн тогтоох саналыг хүсэлтийг тус тус судлан хэлэлцэж байна.</p> <p>Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” МОН-3243 төслийн хүрээнд Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудаар бэлтгэх мэргэжил/хөтөлбөрийн нэр индексийг Боловсролын Олон Улсын Стандарт, Ангилалд нийцүүлэн шинэчлэх судалгааны ажил хийж, салбарын яамдууд, мэргэжлийн холбоод, хүсэлт гаргасан байгууллагуудад албан бичгээр хүргүүлж, санал авч нэгтгэх ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-70%</p> <p><i>4.3 "Мэргэжилтэй ажилтан" хөтөлбөрийг боловсруулах ажлыг "Ажилсаг Монгол" хөтөлбөртэй уялдуулан нэгтгэн зохион байгуулах</i></p>

“Мэргэжлийн боловсрол, сургалт-Ажилсаг Монгол” үндэсний зөвлөгөөнийг Төрийн ордны их танхимд 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд Улсын их хурлын гишүүд, элчин сайд, МБСҮЗ-ийн гишүүн, Монголын ажил олгогч эздийн холбоо, ажил олгогчдын төлөөлөл, МБСБ-ын захирал, багш ажилтан, гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүдийн удирдлагууд, холбогдох мэргэжилтэн, суралцагч, төгсөгчийн төлөөлөл, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл зэрэг нийт 850 хүн оролцов.

"Мэргэжилтэй ажилтан" хөтөлбөрийн төсөл боловсруулах Ажлын хэсгийг ХХААХҮЯамны ТНБД-ын А-430 тоот тушаалаар батлуулан, суурь судалгаа, ажлын төлөвлөгөөг боловсруулсан. Ноос ноолуур, арьс шир, оёдол, ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн уулзалт, хэлэлцүүлгүүдээс мэргэжилтэй ажилтан хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага, зөвлөмж гаргаж, хөтөлбөрийн төслийг танилцуулж байна. Мөн “Үйлдвэржилт 21:100”, “Ноолуур” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн суурь судалгааг үндэслэн хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдлын судалгааг хийсэн. Мөн "Ажилсаг монгол" хөтөлбөртэй хөнгөн үйлдвэрийн салбарын хүний нөөцийн эрэлтийн судалгаа, асрамж халамжаас гарч буй залуусыг ажлын байраар хангах зорилтот төслийг хамран зохион байгуулах ажлыг төлөвлөв.

ХШҮ-40%

4.4 Хөнгөн үйлдвэрийн салбарыг “Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл”-д оруулж, Засгийн газрын 2014 оны 71-р тогтоолд өөрчлөлт оруулах

Засгийн газрын 71-р тогтоолд өөрчлөлт оруулах тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлд хөнгөн үйлдвэрийн 6 салбарыг оруулах тухай саналыг БСШУЯаманд хүргүүлсэн.

ХШҮ-0/30%

4.5 Боловсруулах үйлдвэрийн удирдах болон инженер, техникийн ажилтнуудыг нарийн мэргэжлээр өндөр хөгжсөн оронд давтан сургах, туршилага судлуулах, чадавхижуулах, менежментийн болон технологийн сургалтыг зохион байгуулах

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн дэмжлэгтэй Турк улсад зохион байгуулагдах “Техникийн текстилийн олон улсын сургалт, хурал”-д 4 хүнийг, БНХАУ-д гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр 6 хүнийг, Техник Технологийн Дээд сургуулийн харьяа "Монгол Коосэн" Технологийн Коллежийн 10 оюутан Япон улсын үйлдвэр, компанид 1-4 долоо хоногийн дадлага хийж ирсэн.

Дэлхийн банкны “Экспортыг дэмжих” төслийн санхүүжилтээр Шинжлэх ухаан, технологийн сургуулийн Үйлдвэрлэл технологийн их сургуулийн Шима Сейки сургалтын төвтэй хамтран Япон улсын Шима Сейки фирмийн сүлжмэлийн машины SDS-ONE APEX-3 дизайн системийн анхан шатны болон ахисан түвшний 2 удаагийн сургалтад ноос, ноолуурын үйлдвэрийн инженер, технологич, программист зэрэг 26 оролцогч хамрагдаж сүлжмэлийн SDS-ONE системийн тохиргоо, цэс, түүл, программ хангамжийн автомат тохиргоо, авто процессын параметрууд, оптик шугам, нэхэх, хянах симуляци, сүлжмэл эдлэл хийх, машин механизм, дэлгэцийн машин засвар үйлчилгээ, сүлжмэлийн программ, бүтцийг бэлтгэх зэрэг мэдлэг эзэмшлээ.

Төслийн санхүүжилтээр Ноос ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, экспортлогч аж ахуйн нэгжүүдийн хүсэлтээр Япон улсын Шима Сейки компанийн мэргэжилтэн багш ноён Хонда 2018 оны 9 сарын 19-нөөс 9 сарын 29 хүртэл Шима Сейки заи эзэмшүүлэх сургалтыг удирдан 12 аж ахуйн нэгжийн 13 ажилтанд мэдлэг олгож, ур чадвар эзэмшүүллээ. Сургалтын үр дүнд дижитал системийг

үйлдвэрлэлд нэвтрүүлснээр сүлжмэл бүтээгдэхүүний хэлбэр хэмжээний тооцоолол жигд болох, улмаар чанарын үзүүлэлт дээшлэхийн сацуу программын арга зүйг эзэмшсэнээр цаг хугацаа хэмнэх, шинэ загварын сүлжмэл бүтээгдэхүүний дизайныг сайжруулах, экспортын бүтээгдэхүүнийг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Мөн сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа 12 компанийн хүсэлтээр Штолл фирмийн Хятад дахь албан ёсны төлөөлөгчийн газрын ахлах сургагч багш Яан Зейлянг урьж 2018 оны 11 сарын 5-наас 9 сарын 16 хүртэл 10 өдрийн техникийн түвшний сургалт зохион байгууллаа. Сургалтад эдгээр компанийн машин баригч 12 ажилтан хамрагдаж CMS машины бүтэц зохион байгуулалт, сүлжих, нэхэх технологи, машинд шаардагдах төрөл бүрийн үйлчилгээ, программ хангамжийн асуудлаар онол, практик хосолсон мэдлэг ур чадвар эзэмшиж цаашид ажлын байран дээрээ сургагч багш болох зорилготой юм. Сургалтыг амжилттай төгссөн ажилтнуудад Германы Штолл фирмийн сургалтын гэрчилгээ олгосон.

ХШҮ-100%

4.6 Боловсруулах үйлдвэрийн мэргэжлээр суралцаж байгаа оюутны сургалтын болон төгсөлтийн дадлагын хугацааг уртасгах, сургалт үйлдвэрлэлийн уялдааг хангах, дадлагын үр өгөөжийг дээшлүүлэх

Боловсруулах үйлдвэрийн мэргэжлээр суралцаж байгаа оюутны нийт цаг 3380 байгаагийн үйлдвэр дээрх сургалтын дадлагын цаг 350 цаг байсныг 720 цаг байсныг цаг болгов.

ХШҮ-0/30%

4.8 Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 5 -аас дээш жил ажиллаж буй их, дээд сургуульд элсүүлэн суралцуулах боломжтой нарийн мэргэжилтэй ажилтны судалгаа гаргах

Хөнгөн үйлдвэрийн салбарт 5 -аас дээш жил ажиллаж буй мэргэжилтэй ажилтны судалгаа гаргав.

ХШҮ-70%

4.10 Батлан хамгаалах цэргийн албан хаагчдыг үйлдвэрлэлийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах талаар зохих шатны төрийн байгууллагуудтай хамтран ажиллах

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам"-ыг боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2018 оны 01 дүгээр зарлигаар батлуулсан.

Мөн "Автозамын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах түр журам"-ыг боловсруулан сайдын 2018 оны А/217 дугаар тушаалаар батлуулсанаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Засгийн газрын 2018 оны 2, 21 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2018 оны 09 дүгээр тогтоолын хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн хүнд даацын тусгай зориулалтын авто замын барилгын ажлын гэрээг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-тай байгуулан ажиллаж байна. Уг бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай худалдан авалтыг Батлан хамгаалахын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А-201/169 дүгээр тушаалын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Бүтээн байгуулалтын ажил батлагдсан гэрээ, төлөвлөгөөгөөр 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүлээлгэж өгөх бөгөөд 2018 онд төлөвлөгдсөн ажлыг 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрөөс 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилж, төлөвлөгөөний дагуу явагдаж байна.

		<p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p><i>4.11 Асрамж, халамжийн газарт өсөж хүмүүжсэн зорилтот бүлгийн иргэдийг үйлдвэрлэгчидтэй хамтран мини төсөлд хамруулах</i></p> <p>Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017)-ийн 4.1.1 дэх хэсэгт "зорилтот бүлгийн залуучууд гэж хэвийн ажиллаж амьдрахад нийгмийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1 болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.7 дахь хэсэгт заасан залуучуудыг ойлгоно"; 15.1.3 дахь хэсэгт "Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулна" гэж тус тус заасныг үндэслэн Асрамж, халамжийн төвд өсч хүмүүжин насанд хүрч нийгмийн харилцаанд орж буй залуучуудыг дэмжих төслийг боловсруулж байна. Ингэхдээ аймаг, дүүрэг тус бүрд зорилтот бүлгийн тодорхой тооны залуучуудыг нийгмийн харилцаанд бэлтгэх зөвлөгөө, сургалтанд хамруулах, бие даан амьдрахад тулгарах аливаа бэрхшээлийг даван туулах, мэргэжил эзэмших болон хөдөлмөрийн зах зээлд ороход mentor буюу амьдралын зөвлөгчийн зөвлөгөө, дэмжлэгээр хангах зэргээр амьдрах байр, өдөр тутмын амьжиргааны зардлыг тусгасан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, үүнд аймаг, дүүргүүдийн ГБХЗХГ болон ЗХТ-ийн оролцоог хангах байдлаар тусгаад байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p> <p><i>4.12 Гадаад оронд ажиллаж байсан, шинэ технологи эзэмшсэн иргэдийг эх орондоо иргэн ирж тухайн чиглэлээр үйлдвэрлэл явуулахад санхүү, татварын дэмжлэг үзүүлэх</i></p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 сарын 27-ны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 4.4-т Гадаадад ажиллаж, амьдарч байгаад сүүлийн 2 жилийн дотор эх орондоо ирсэн иргэн өөрийн эзэмшсэн мэргэжил, ур чадварын дагуу гарааны бизнес эрхлэхийг дэмжих арга хэмжээг 2018 онд хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээний хүрээнд 5.0 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 36 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр нэг удаа олгохоос гадна аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт, борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт арга хэмжээнүүдэд хамруулж байна.</p> <p>2018 оны 11 дүгээр сарын байдлаар дээрх хөтөлбөр, арга хэмжээнүүдэд гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн 25 иргэнийг хамруулж 125.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэгт хамруулаад байна.</p> <p>ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2018 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А-582 тоот тушаалаар "ЖДҮ-ийн хөгжилд БНСУ-д ажиллаж амьдарч буй Монголчуудын оролцоо" арга хэмжээг зохион байгуулав..</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
Зорилт 4-ийн дундаж үнэлгээ 62.2%		
	<p>5-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-ложистикийг боловсронгуй болгож, маркетингийг эрчимжүүлэн гадаад, дотоод худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх:</p>	<p><i>5.3 Үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг олон улсын худалдааны сүлжээнд хамруулах боломжийг судлах, худалдааны сүлжээнд хамруулах</i></p> <p>Дэлхийн банкны экспортыг дэмжих төслөөс ноос, ноолуур, махан бүтээгдэхүүнийг экспортлоход шаардлагатай эрх зүйн баримт бичгийг судалж, БНХАУ, ОХУ-ын стандарт, эрхзүйн бичиг баримтуудыг орчуулан боловсруулах ажил хийгдэж байна. Нийт 45 аж ахуйн нэгж экспортын хөгжлийн төлөвлөгөө боловсруулж бараа бүтээгдэхүүнээ экспортлох гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээ байгуулсан үйлдвэрлэлийн чиглэлд ноос ноолуурын 7, тавилгын1,</p>

хүнсний 5, гоо сайхны 1, гар урлалын 3, эрүүл мэнд бүтээгдэхүүний 1, АТ-ийн 2, аялал жуулчлалын 3, салхин сэнсний 1 аж ахуйн нэгж орж байна.

Экспортыг дэмжих төслийн хүрээнд Монголын экспортлогчдыг шинэ зах зээлд нэвтрэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сурталчлах, зах зээлээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, гадаад түнштэй холбох зорилгоор МҮХАҮТ-тай хамтран "MONGOLIAN EXPORTERS-2018" цахим каталогийг боловсруулан exporters.mongolchamber.mn цахим хуудсаар болон CD хэлбэрээр танилцуулж байна.

Цахим каталогт Монгол Улсын 100 гаруй аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг 9 салбарт ангилан танилцуулга, зураг хэлбэрээр оруулснаас гадна экспортын зарим баримт бичгүүдийн загвар зэрэг мэдээллүүдийг багтаасан болно. Ингэснээр олон улсын бизнес уулзалт, үзэсгэлэн яармагийн арга хэмжээ, Монголд болон гадаадад суугаа элчин сайдын яамд, худалдааг дэмжих байгууллагууд, МҮХАҮТ-ын гадаад орнууд дахь төлөөлөгчдөөр дамжуулан дэлхийн зах зээлд үнэ төлбөргүй сурталчлах боломжтой болсон.

ХШҮ-70%

5.4 Европын холбоо, АНУ-н ХЕС болон Монгол Японы ЭЗТХ-ийн хүрээнд үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх судалгааг хийх, дэмжлэг үзүүлэх

ЕХУ-аас хэрэгжүүлж байгаа TRAM төслөөс Монгол улсаас экспортлох боломжтой бараа бүтээгдэхүүнийг судалж мах, чацаргана, ноос ноолуур, гоо сайхан, аялал жуулчлалын чиглэлийн 5 кластераар хөгжүүлэх чиглэл гарч судалгаа хийгдсэн.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” техник туслалцааны төслийн хүрээнд “Чацарганы гадаад зах зээлийн судалгаа”-ны ажлын гэрээг Бодлогын шийдэл ТББ-тай байгуулж ажлыг эхлүүлэв.

ХШҮ-70%

5.5 Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах

Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулах чиглэлд саналыг бүхий л түвшинд илэрхийлж байна. ОХУ-ын зүгээс Евроазийн эдийн засгийн холбооны хүрээнд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар асуудлыг шийдвэрлэх нь зохистой гэсэн санааг удаа дараа илэрхийлсэн бөгөөд Евроазийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгаан ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Евроазийн эдийн засгийн холбооны дүрэм, журмын дагуу гишүүн орон бүрээс хамтарсан судалгаа хийх зөвшөөрөл авах ёстой. Үүний дагуу Казакстан, Киргиз, Беларусь улсаас зохих зөвшөөрлийг аваад байна. Армени улсаас зөвшөөрөл авах чиглэлээр ажиллаж байна.

Монгол Оросын худалдааны хэмжээ 2017 онд 1.28 тэрбум ам.доллар, 2018 онд 1.79 тэрбум ам.долларт хүрч 39% аар нэмэгдэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор байгуулагдсан "Монгол Оросын санаачилга- 2018" цуврал арга хэмжээний хүрээнд Оросын дэвшилтэд техник технологи хөдөө аж ахуйн техникийн үзэсгэлэнг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Оросын талаас 130 гаруй бизнесийн төлөөлөл, Монголын талаас 400 гаруй компаний төлөөлөл оролцлоо.

Сибирийн олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс Орост үйлдвэрлэв бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг 2 дах удаагаа Улаанбаатарт зохион байгуулав.

ХШҮ-40%

5.6 Монгол брэнд бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд сурталчлах, таниулах "Хаан ширхэгт" брэндийг үйлдвэрлэн, гэрчилгээ олгох, сурталчлах

Монголын оюуны өмчийн газрын 10876 дугаартай ХХААХҮЯ эзэмшдэг "Монголын Хаан Ширхэгт" "ноос, ноолуурын чанарын тэмдгийг дэлхийн 33 улсын Оюуны өмчийн газарт хамгаалалтад бүртгүүлсэн. Тус гэрчлэх тэмдгийг олгох үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр ХХААХҮСайдын А-167 тоот тушаалын дагуу 181018/06-400 тоот гэрээг МННХ-той 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан.

ХХААХҮЯ-ны захиалгаар ШУТ-ийн сангийн 42.1 сая төгрөгийн санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Жинст мөрөн компани, Хөвсгөл аймгийн Бэлчээр ашиглалтын холбоо хамтран Төмөрбулаг, Арбулаг, Алаг-Эрдэнэ, Улаан-Уул, Түнэл сумдын малчидтай хамтран "Богино ширхэгтэй ноолуураар ээрмэл үйлдвэрлэх технологийн шийдэл" сэдэвт төслийг 2016-2018 онд хэрэгжүүлсэн.

Төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн дээрх сумдын малчдад 1-3 настай ямааны ноолуурыг тусгайлан бэлтгэх сургалтыг явуулсаны үр дүнд 13,5-15,5 мкм нарийнтай борлонгийн ноолуурыг бэлтгэж, 26/2 номерын ээрмэлийг үйлдвэрлэсэн. Энэхүү нарийн ширхэгтэй ээрмэл нь "Монголын хаан ширхэгт" брэндийн шалгуурыг хангаж, тус брэндийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд загвар болж байгаа юм.

"Монгол экспорт экспо" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар МННХолбоо, Арьс, ширний үйлдвэрлэлийн холбоо, Мишээл экспо ХХК-тай хамтран ажиллаж, тус арга хэмжээний үеэр ХХААХҮЯ, АХБ-ны "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт" төсөл: Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээ техник туслалцаа төсөл хамтран "Монголын хаан ширхэгт бүтээгдэхүүний чанар, стандарт" семинарыг Монголын хаан ширхэгтийн танилцуулга, чанарын тогтолцоо, эцсийн бүтээгдэхүүний стандартын санал, бүтээгдэхүүнд хийсэн чанарын хяналт зэрэг асуудлыг танилцуулав.

Дээрх төсөлтэй хамтран "Монголын хаан ширхэгт" гэрчлэх тэмдгийг баталгаажуулах тогтолцоонд оролцогч талууд /ХХААХҮЯ, Монголын ноос ноолуурын холбоо, Стандартчилал хэмжилзүйн газар, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн, Үйлдвэрлэгчид-ын хамтарсан уулзалт зөвөлгөөнийг зохион байгуулсан. Оролцогчид "Монголын Хаан Ширхэгт" гэрчлэх тэмдэгтийг баталгаажуулах хөтөлбөрийн бүтэц зохион байгуулалт, талуудын оролцоо, уг тэмдэгтийг олгох зарим эрх үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, "Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих" төслийн явц, бүтээгдэхүүний баталгаажуулалт, чанарын тохирлын үнэлгээ хийх, сорил болон итгэмлэгдсэн лабораторийн оролцоо зэрэг асуудалд төвлөрч ярилцсан.

Уг семинарыг "Ноолуур" хөтөлбөрт тусгасан "Монгол ноолуурын өнгө, давуу шинж чанарт тулгуурлан "Монголын Хаан Ширхэгт" брэндийг хөгжүүлж, зах зээлд таниулах, сурталчлах" гэсэн ажлын хүрээнд зохион байгуулав.

ХШҮ-100%

5.8 "Нэг сум-нэг брэнд" аян өрнүүлэх

Архангай, Баянхонгор, Завхан, Хэнтий зэрэг аймагт "Нэг суурин-нэг бахархал" аяныг өрнүүлэн сумдын шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Шилдэг брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг шалгаруулан үйлдвэрлэгч

нарыг идэвхжүүлэн аяны хүрээнд сургалт, үзэсгэлэн худалдааг жилд 2-оос доошгүй зохион байгуулсан байна.

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар батлагдсан "Улаанбаатарт үйлдвэрлэв" дэд хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн борлуулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлж бүтээгдэхүүний чанар стандартыг сайжруулах, шинэлэг бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Улаанбаатарт үйлдвэрлэв 2018" үзэсгэлэн худалдааг 3 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 553 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулж үзэсгэлэн худалдааны түрээсийн төлбөрийг хөтөлбөрийн санхүүжилтээс шийдвэрлэн үйлдвэрлэгч нарыг үнэ төлбөргүй хамруулж бараа бүтээгдэхүүний чанар, стандарт баглаа боодлыг сайжруулах тал дээр байнгын зөвлөгөө өгч ажиллав. Үзэсгэлэн худалдаанд оролцсон үйлдвэрлэгчдээс шинэ санаа, шилдэг технологийг нэвтрүүлсэн цаашдын дотоодын төдийгүй гадаад зах зээлд борлуулах боломжтой 9 үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг шилдэг үйлдвэрлэгчээр шалгаруулан НЗД-ын батламж гардуулсан.

ХШҮ-70%

5.9 Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг худалдааны түний орнуудад сурталчлах, ЭКСПО-д оролцоход дэмжлэг үзүүлэх

Япон улсын Токио хотноо зохион байгуулагддаг "Fashion World Tokyo", АНУ-ын Нью Йорк хотноо зохион байгуулагддаг "Fashion Coterie" олон улсын үзэсгэлэнд 2, 10 дугаар саруудад ноос, ноолуурын үйлдвэрүүдийг "Mongolian Cashmere" нэгдсэн нэрийн дор зохион байгуулж оролцуулахад МННХ-той хамтран ажилласан ба тус улсуудад гаргаж буй экспортын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 20-30% нэмэгдсэн байна. Мөн дотооддоо "Монгол экспорт экспо" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, үзэсгэлэн худалдаанд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 40 гаруй аж ахуйн нэгжийг оролцуулсан ба энэ үеэр 180 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн экспортыг нэмэгдүүлэх зорилгоор бизнес стратегийн төлөвлөлт, үйлдвэрлэлийн менежментийн шинэчлэл, бүтээгдэхүүний чанарын туршилт болон гэрчилгээ авах, бүтээгдэхүүн нэвтрүүлэлт, экспортын яармаг, үзэсгэлэн худалдаанд оролцохтой холбоотой зөвшөөрөгдсөн зардлуудыг "Экспортыг дэмжих" төслийн санхүүжилтээр олгосон. 2018 оны байдлаар ноос, ноолуур, нэхмэлийн 27 аж ахуйн нэгжид нийт 133 000 гаруй ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Япон, АНУ зэрэг олон улсын үзэсгэлэнд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжин оролцуулж байна. 2017 онтой харьцуулахад Япон улсад гаргасан экспортын хэмжээ 28.9%, АНУ-д гаргасан экспортын хэмжээ 67%-иар тус тус нэмэгдсэн.

Япон улсад 2018 оны 03 дугаар сард зохион байгуулагдсан олон улсын FOODEX хүнсний үзэсгэлэнд 4 аж ахуйн нэгж оролцуулав.

БНХАУ-ын Эрэн хотод 2018 оны 08-р сард зохион байгуулагдсан "Хятад, Монгол, Оросын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа– 2018" чуулга уулзалтын үеэр зохион байгуулагдсан үзэсгэлэн худалдаанд Монголын талаас ноос, ноолуур, арьс шир, хүнсний үйлдвэрлэлийн 70 орчим аж ахуйн нэгж оролцсон.

Монголын үйлдвэрлэлийг дэмжих Холбоотой хамтран ӨМӨЗО-ны Тонгляо хотын үзэсгэлэнд 90 орчим ААН үйлдвэрлэгчдийг хамруулав.

ГХЯам, Япон улсын Токио хот дах Монгол улсын Элчин сайдын яам, ХХААХҮЯамны харьяа ЖДҮХСан, Хөгжлийн банк, Экспорт олон улсын худалдааны төв байгууллагууд хамтран 2018 оны 6

		<p>дугаар сард Япон улсын Токио хотод “Монгол-Японы бизнес форум” үзэсгэлэнгийн арга хэмжээг зохион байгуулсан. Тус Форумд Япон улсаас Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Жижиг дунд бизнесийг дэмжих төв байгууллага тэргүүтэй 120 гаруй бизнес эрхлэгчид, Монгол улсаас 15 байгууллага оролцлоо.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p><i>5.12 УБ хотын баруун, зүүн талд мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, ногооны төрөлжсөн бөөний худалдааны төв байгуулахад дэмжлэг үзүүлэх</i></p> <p>Улаанбаатар хотын нийт махны хэрэглээний 10-15 хувийг хангах /1500 бод, 7500 богийн/ хүчин чадал бүхий мал нядлах үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, мал зарах задгай талбай бүхий үйлдвэрийн цогцолбор барилгын төслийг 2017 онд эхлүүлсэн. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд "МБҮ Трейд" ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2017 он А/516 дугаар захирамжаар 21.2 га газрыг Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо, БЗД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шийдвэрлүүлэн тус компанитай газар ашиглах гэрээг байгуулсан.</p> <p>Төслийн ТЭЗҮ болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчны үнэлгээ батлагдан, ажлын зураг төсөл хийгдээд байна. Зүүн бүсийн барилга угсралт, үйлдвэрийн барилга баригдсан бөгөөд инженерийн шугам сүлжээ татагдсан. Баруун бүсийн барилга угсралтын ажлын хувьд нийт 260000 м3 газар шороо тэгшилгээний ажил дууссан. Барилгын суурийн ажил, металл /каркас/ угсалтын ажил 100%-ийн гүйцэтгэлтэй, сэндвич хавтанг угсрах бэлтгэл ажил 70%, суурийн өрлөгийн ажил 60%, шалны цутгалтын ажил 50%, гадна зам талбай, гадна инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цахилгааны ажлууд 30-40%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.</p> <p>Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулах ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, Гүйцэтгэгчээр шалгарсан “ХБХДТ” ХХК -тай гэрээ байгуулж ажил хүлээж авсан.</p> <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <p><i>5.13 Сав, баглаа боодлын захиалгын болон худалдааны цэгийг байгуулахад дэмжлэг үзүүлэх</i></p> <p>Засгийн газрын 287 дугаар тогтоолоор батлагдсан "Сав баглаа боодол" хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд түүхий эд, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, захиалгын төв байгуулах саналыг хэлэлцүүлэн, судалгааг хийхээр мэргэжлийн холбоотой хамтран бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ-40%</p>
Зорилт 5-ийн дундаж үнэлгээ 70.0%		
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололттой тал:</p> <p>“Үйлдвэржилт 21-100” Үндэсний хөтөлбөр нь уул уухайн олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс бусад аж үйлдвэрийн салбар хамаарч байгаа цар хүрээ өргөнтэй чухал бодлогын баримт бичиг боловсруулан ЗГ-ын 36 дугаар тогтоолоор батлуулан 2018 онд батлуулсан. Талант 2018 онд 5 зорилт 43 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, хэрэгжилт 74.8% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” хэмээн үнэлэгдэв.</p> <p>Хөтөлбөрийн хүрээнд нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой үр дүн, үр нөлөөг бий болгох аж үйлдвэрийг хөгжүүлэх бүтээн байгуулалтын томоохон ажлууд хийгдэж байна. Шалгуур үзүүлэлтийн биелэлтээс харахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, улсын төсөвт тусгах хөрөнгийг</p>

		<p>бодлогоор дэмжиж, төлөвлөсөн зорилтын дагуу хэрэгжилтийг зохион байгуулвал энэ хөтөлбөр тавьсан зорилтот түвшиндөө хүрч, зорилгоо биелүүлэх боломжтой гэж үзэж байна.</p> <p><u>Дутагдалтай тал, түлгамдсан асуудал:</u></p> <ul style="list-style-type: none"> ➢ Үндэсний хөтөлбөрийн биелэлтэд ирүүлж буй тайланд санхүүгийн гүйцэтгэлээ тусгахгүй байгаа нь нэгтгэх дүгнэх, төлөвлөхөд хүндрэлтэй байна. ➢ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 3,045.0 тэрбум төгрөг төлөвлөсөн боловч 2018 онд 6.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь ХХААХҮ-ийн салбарт хэрэгжүүлэх энэ том төслийг хэрэгжүүлэхэд улсын төсөв болон орон нутгийн төсөвт хувийн хэвшлийг дэмжихэд үзүүлэх хөрөнгө оруулалтыг бодлогоор зээл, тусламжид хамруулах, дэмжих шаардлагатайг харуулж байна. 2018 оны Үндсэн чиглэлд тусгагдсан Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. 						
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУ-ын төсөл хөтөлбөрүүд, үйлдвэр аж ахуй нэгж, иргэд хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээнд хийгдэж байгаа хамтын ажиллагаа, уялдаа холбоог “Хангалттай” гэж үнэлж байна.						
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		74.8 %	5	85.0	92.5	70.0	57.8	68.8
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						
		... %						

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	нэгж	Суурь түвшин, он	Хүрсэн түвшин	Зорилтот түвшин, он	Суурь онтой харьцуулсан хувь 2018/2016
			2016	2018	2021	
1.	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	хувь	9	11.3	15	125.5
2.	Арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	36	37.2% АШҮХ	60	103.3
3.	Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	20	26%	60	130.0
4.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн махны үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	6	Урьдчилсан гүйцэтгэлээр 11.4%	30	190.0
5.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн сүүний үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	9	10%	40	111.1
6.	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо	тоо	-	30	100	
7.	Шинээр бий болгох ажлын байр (хүний тоо)	тоо	-	2000 гаруй	6000	
8.	Олон улсын түвшинд хүрсэн стандартын нийт стандартын дүнд эзлэх хэмжээ	хувь	42	33%	50	78.6